

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/260-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: З.Золбоо
	Утас: 70362442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8. Аудитын гол асуудал	16
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.15 № СЭА-2022/260-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.САРАНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,368,628.55	82,497,801.40
35	БАРАА МАТЕРИАЛ	46,368,628.55	82,497,801.40
351	Түүхий эд материал	22,780,623.55	27,526,176.40
35110	Тусгай зориулалттай материал	22,780,623.55	27,526,176.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	635,580.00	650,580.00
354	Хангамжийн материал	22,952,425.00	54,321,045.00
35410	Бичиг хэргийн материал	-	3,926,820.00
35420	Аж ахуйн материал	22,952,425.00	31,411,725.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	539,000.00
35450	Барилгын засварын материал	-	194,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	18,249,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	75,376,548.57	245,251,489.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	75,376,548.57	245,251,489.81
392	Биет хөрөнгө	71,056,548.57	240,931,489.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,400,000.00	29,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(408,333.33)	(5,308,333.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,689,329.61	339,109,879.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(237,072,355.51)	(124,072,086.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,460,391.50	21,174,411.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,012,483.70)	(19,372,381.67)
393	Биет бус хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
39301	Програм хангамж	7,043,200.00	7,043,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,043,200.00)	(7,043,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	121,745,177.12	327,749,291.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	121,745,177.12	327,749,291.21
51	Засгийн газрын хувь оролцоо	121,745,177.12	327,749,291.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,320,000.00	4,320,000.00
51101	Өмч: - төрийн	4,320,000.00	4,320,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	117,425,177.12	323,429,291.21
51210	Өмнөх үеийн үр дүн	117,425,177.12	117,425,177.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	206,004,114.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	121,745,177.12	327,749,291.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	899,167,068.90	1,005,946,757.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,667,568.90	270,144,657.49
120	Нийтлэг татварын бус орлого	80,667,568.90	270,144,657.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,667,568.90	270,144,657.49
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,667,568.90	270,144,657.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	818,499,500.00	735,802,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	695,136,800.00	680,294,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	695,136,800.00	680,294,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,362,700.00	55,507,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,362,700.00	55,507,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	848,786,498.88	798,265,643.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	848,786,498.88	798,265,643.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,067,398.88	797,376,343.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,159,000.00	569,906,700.00
210101	Үндсэн цалин	461,254,179.00	447,392,620.90
210102	Нэмэгдэл	93,688,821.00	110,902,379.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,216,000.00	11,611,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,150,500.00	78,884,400.00
210201	Тэтгэврийн даатгал	69,335,900.00	59,005,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,453,700.00	4,969,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,362,900.00	3,975,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,090,700.00	994,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,907,300.00	9,939,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,784,000.00	12,821,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,326,400.00	2,882,900.00
210302	Түлш, халаалт	8,557,600.00	7,702,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,580,000.00	2,236,000.00
210304	Байрны түрээс	1,320,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,036,800.00	25,491,275.00
210401	Бичиг хэрэг	8,153,900.00	5,322,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,283,200.00	2,065,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,312,700.00	3,672,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250,000.00	13,476,280.00
210408	Бараа материал акталсны зардал	-	955,295.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,869,300.00	8,190,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,500.00	818,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	966,800.00	7,318,600.00
210604	Урсгал засвар	1,102,000.00	53,000.00
2107	Томилолт, зочны зардал	649,300.00	305,000.00
210702	Дотоод албан томилолт	649,300.00	305,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,997,457.80	16,790,447.15

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	551,000.00	690,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	31,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,855,957.80	15,957,847.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,421,041.08	84,987,021.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,362,700.00	55,507,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,594,100.00	1,144,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,464,241.08	28,335,821.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	719,100.00	889,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	719,100.00	422,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	719,100.00	422,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	466,900.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	466,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	50,380,570.02	207,681,114.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,677,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,677,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,677,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	50,380,570.02	206,004,114.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	200 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,320,000.00	-	67,044,607.10	-	71,364,607.10
2	Нягтлан бодох бүртгэлийн	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	-	75,175,482.91	-	79,495,482.91
7	Тайлант үеийн үр дүн	-	-	50,380,570.02	-	50,380,570.02
8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,320,000.00	-	117,425,177.12	-	121,745,177.12
9	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,320,000.00	-	117,425,177.12	-	121,745,177.12
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	-	117,425,177.12	-	121,745,177.12
16	Тайлант үеийн үр дүн	-	-	206,004,114.09	-	206,004,114.09
17	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,320,000.00	-	323,429,291.21	-	327,749,291.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,084,661,127.02	1,141,078,508.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	266,161,627.02	405,276,408.54
120	Нийтлэг татварын бус орлого	266,161,627.02	405,276,408.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	266,161,627.02	405,276,408.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,161,627.02	405,276,408.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	818,499,500.00	735,802,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	695,136,800.00	680,294,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	695,136,800.00	680,294,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,362,700.00	55,507,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,362,700.00	55,507,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,084,661,127.02	1,141,078,508.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,084,661,127.02	1,141,078,508.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	817,780,400.00	734,912,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,159,000.00	569,906,700.00
210101	Үндсэн цалин	461,254,179.00	447,392,620.90
210102	Нэмэгдэл	93,688,821.00	110,902,379.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,216,000.00	11,611,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,150,500.00	78,884,400.00
210201	Тэтгэврийн даатгал	69,335,900.00	59,005,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,453,700.00	4,969,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,362,900.00	3,975,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,090,700.00	994,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,907,300.00	9,939,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,784,000.00	12,821,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,326,400.00	2,882,900.00
210302	Түлш, халаалт	8,557,600.00	7,702,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,580,000.00	2,236,000.00
210304	Байрны түрээс	1,320,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	15,070,000.00	13,761,500.00
210401	Бичиг хэрэг	8,153,900.00	5,967,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,283,200.00	2,065,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,312,700.00	3,672,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,283,200.00	2,057,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,869,300.00	1,750,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,500.00	725,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	966,800.00	556,000.00
210604	Урсгал засвар	1,102,000.00	469,000.00
2107	Томилолт, зочны зардал	649,300.00	305,000.00
210702	Дотоод албан томилолт	649,300.00	305,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,141,500.00	832,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	551,000.00	690,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	31,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,956,800.00	56,651,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,362,700.00	55,507,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,594,100.00	1,144,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	266,880,727.02	406,165,708.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	719,100.00	422,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	719,100.00	422,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	266,161,627.02	405,743,308.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	266,161,627.02	405,743,308.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	680,294,900.00	679,828,000.00	466,900.00	99.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	680,294,900.00	679,828,000.00	466,900.00	99.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,872,500.00	679,405,600.00	466,900.00	99.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,906,700.00	569,906,700.00	-	100.00
210101	Үндсэн цалин	447,392,700.00	447,392,620.90	79.10	100.00
210102	Нэмэгдэл	110,902,300.00	110,902,379.10	(79.10)	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,611,700.00	11,611,700.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,884,400.00	78,884,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	59,005,200.00	59,005,200.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,969,800.00	4,969,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,975,800.00	3,975,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	994,000.00	994,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,939,600.00	9,939,600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,821,000.00	12,821,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,882,900.00	2,882,900.00	-	100.00
210302	Түлш, халаалт	7,702,100.00	7,702,100.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,236,000.00	2,236,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,804,000.00	13,761,500.00	42,500.00	99.69
210401	Бичиг хэрэг	5,967,000.00	5,967,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,065,500.00	2,065,500.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,672,000.00	3,672,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,500.00	-	42,500.00	-

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,057,000.00	2,057,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,949,400.00	1,750,400.00	199,000.00	89.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	924,400.00	725,400.00	199,000.00	78.47
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	556,000.00	556,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	469,000.00	469,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	305,000.00	305,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	305,000.00	305,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,058,000.00	832,600.00	225,400.00	78.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,000.00	690,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	-	224,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	89,100.00	900.00	99.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,000.00	31,500.00	500.00	98.44
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,144,000.00	1,144,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,144,000.00	1,144,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	422,400.00	422,400.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	422,400.00	422,400.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	422,400.00	422,400.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	680,294,900.00	679,828,000.00	466,900.00	99.93
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	680,294,900.00	679,828,000.00	466,900.00	99.93
310001	Улсын төсвөөс санхүүжих	680,294,900.00	679,828,000.00	466,900.00	99.93
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89.00	89.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	44.00	44.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	44.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	38.00	38.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		55,507,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		55,507,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		55,507,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		55,507,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		55,507,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		55,507,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		55,507,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		55,507,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /цаашид Улсын бүртгэлийн хэлтэс гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, нэмэлт санхүүжилтээр худалдан авсан бараа материалыг тооцооны дансаар дамжуулж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 89 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулах,
- Суманд бүртгэгдсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг төв сүлжээнд шууд дамжуулж, мэдээллийн санг бүрдүүлэх,
- Бүх нийтийн эрх зүйн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах,
- Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Иргэний улсын бүртгэлтэй холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдлага, арга зүйгээр хангах
- Эд хөрөнгийн эрхийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу улсын бүртгэлд бүртгэх болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах,

- Эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн цахим санг ашиглах,
- Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах,
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах,
- Хэлтсийн албан хаагчдыг төрийн захиргааны удирдлагаар хангаж, бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд ил тод, чирэгдэлгүй хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус хэлтсийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 849,621.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,496.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,372.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 206,004.1 мянган төгрөгөөр буюу 2.6 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	46,368.6	82,497.8	36,129.2
Үндсэн хөрөнгө	75,376.6	245,251.5	169,874.9
Нийт хөрөнгө	121,745.2	327,749.3	206,004.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	121,745.2	327,749.3	206,004.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	121,745.2	327,749.3	206,004.1

Бараа материалын дансны үлдэгдэл 82,497.8 мянган төгрөг болж өмнөх оноос 36,129.2 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас 71,933.9 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 11,825.7 мянган материалыг худалдан авч, 1,677.0 мянган төгрөгийн бараа материалыг УБЕГ-т шилжүүлсэн, тус газрын даргын 2021 оны А/34 дүгээр тушаалаар 955.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хасаж, 44,998.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 401,047.5 мянган төгрөг болж өмнөх оноос 65,134.6 мянган төгрөгөөр өссөн нь БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Койка”-ийн санхүүжилтээр хэрэгжсэн “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд 196,870.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар, УБЕГ-аас 4,427.9 мянган төгрөгийн 21 тавилгыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 14 тавилгын үнийг шинэчлэн тогтоож, үнэлгээний зөрүү болох 305.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, 1,018.9 мянган төгрөгийг дахин үнэлгээний хоргодлоор бүртгэсэн болон ТӨБЗГ-ын 2021 оны 720 дугаар тогтоолоор 135,450.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 327,749.3 мянган төгрөг болж 206,004.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 106,779.7 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн нь УБЕГ болон БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Койка”-ийн санхүүжилтээр үнэ төлбөргүй болон хандиваар хөрөнгө орлогод авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 50,520.8 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан нь ажил олгогчоос төлөх НДШ болон бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний төлбөр зэрэг зардлууд буурснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 761,564.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 162,539.0 мянган төгрөгөөр бууруулж 680,294.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 18,016.2 мянган төгрөгөөр, НДШ-ийг 1,661.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 3,299.4 мянган төгрөгөөр, бараа материалын зардлыг 20,298.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 7,350.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 7,086.6 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 8,428.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,506.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 13,077.6 мянган төгрөгөөр зэрэг нийт 162,993.0 мянган төгрөгөөр бууруулсан болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 454.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 680,294.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 679,828.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 679,828.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг нийт 422.4 мянган төгрөгөөр хэмнэж оны эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардалд тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 55,507.2 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус хэлтэст УБЕГ-аас зах зээлийн үнээс өндөр үнэ бүхий бараа материал шилжүүлсэн бөгөөд жилийн эцэст хангамжийн материал дансанд нийт 16,828.0 мянган төгрөгийн /179 ширхэг 3,580.0 мянган төгрөгийн гар ариутгагч, 7360 ширхэг 13,248.0 мянган төгрөгийн хамгаалах маск/ бараа материалын нөөц үүсгэсэн байна. Үүнд: Баатар брэндийн 500 мл савлагаатай “Цэвэр гар” гар ариутгагчийн зах зээлийн үнэ 10.0 мянган төгрөг байхад нийлүүлсэн үнэ 20.0 мянган төгрөг, хамгаалах маск буюу KF-94 маск /10 ширхэгтэй/-ны зах зээлийн үнэ 5.0-9.0 мянган төгрөгийн хооронд байхад 18.0 мянган төгрөгийн үнээр шилжүүлж данс бүртгэлд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын бүртгэлийн хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Улсын бүртгэлийн хэлтсийн тайлант оны үйл ажиллагаанд 680,294.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 679,828.0 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.1 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 7,723.3 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	7,723.7	3	7,723.7	100
Нийт дүн	3	7,723.7	3	7,723.7	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар бүх ажил гүйлгээг тулган баталгаажуулах боломжгүй байсан бөгөөд дараагийн аудитаар тусгай зориулалтын материал /үнэт цаасны тайлан/-ын зарцуулалтыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41,261.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 669.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,871.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, 36,720.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

1. Сайхан сумын улсын бүртгэгч Ц.Сонинзулд олгосон цалингийн урьдчилгаа 309.2 мянган төгрөгийг суутгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Бичиг хэргийн материалын жилийн эцсийн үлдэгдлийг үнэн зөв тоолж, баталгаажуулаагүйгээс 360.0 мянган төгрөгийн принтерийн хор дутагдсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутагдсан бараа материалын үнийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр 3 албан хаагчид 2020 оны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй гэх үндэслэлээр тайлант оны батлагдсан төсвөөс 3,871.5 мянган төгрөгийн цалин олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх *"Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.3 дахь *"бүх өр төлбөр"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Аудитаар 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

1.Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,900.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт бөөн дүнгээр шивэгдсэн, 28,117.5 мянган төгрөгийн

бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд нэмэлт санхүүжилтээр худалдан авч, зарцуулсан 4,790.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,150.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 763.0 мянган төгрөгийн хангамжийн материал зэрэг нийт 6,703.0 мянган төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21-дахь “Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед дт-хангамжийн материал, кт-мөнгөн хөрөнгө/дансны өглөг” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын орлого, зарлагыг тухай бүр тооцооны дансаар дамжуулж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		4	41,261.2	-	-	1	669.2	1	3,871.5	2	36,720.5